

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСЭЭС
ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТОЙ БУУРУУЛАХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН ТАЙЛАН**

2024.11.19

Сүмбэр сум

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг баталсан бөгөөд Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 50 дугаар тушаалаар "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-г баталсан. Тус хэлтэс нь Гамшигаас хамгаалах төлөвлөгөөг 2024 оны 1 дүгээр улиралд батлуулан ажиллаж байна.



Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэн аймгийн Онцгой байдлын байгуулагатай хамтран ажиллаж албан хаагчдад "Гал түймэр", "Газар хөдлөлт, гамшигаас хамгаалах төлөвлөгөө" сэдвээр гамшигаас хамгаалах мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан.

Цагаан сар болон үндэсний их баяр наадмын амралтын өдрүүдэд хэлтсийн байр, өрөө тасалгаанууд, иргэдэд үйлчлэх танхим болон компьютер тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, гэнэтийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хариуцлагатай жижүүрийг 2 удаа хэлтсийн даргын тушаалаар томилон ажиллуулсан.

Монгол Улсын Шадар сайд, Говьсүмбэр аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний дагуу Онцгой байдлын ерөнхий газраас тус аймагт Гамшигаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулсан. Говьсүмбэр аймгийн Онцгой Комиссын 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 73 дугаартай албан бичгээр тус аймагт 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр "Гамшигаас хамгаалах бэлэн байдлын үзлэг болохтой холбогдуулан томилгоот Гамшигаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн хүн хүч, техник хэрэгсэл, нэг бүрийн бэлэн байдал /аранз/ жагсаалын жигдэрэлт хангах 4 удаагийн бэлтгэл ажилд 11 дүгээр сарын 06,08,11,13-ны өдрүүдэд заасан хугацааны дагуу тус хэлтсийн 5 албан хаагч Гамшигаас хамгаалах бүх албадын шуурхай штабын байнгын байрны иж бүрдэл, тоног

төхөөрөмж, техник хэрэгсэл, хүн нэг бүрийн хээрийн үүргэвчинд байх 15 нэр төрлийн зүйлийг бүрдүүлж байнгын бэлэн байдлын жагсаалд хамрагдсан.



Говьсүмбэр аймгийн Гамшигаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг ОБЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг 11 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд хэлтсийн 5 албан хаагч хамрагдан цагийн менежмент дээр ажилласан. Үзлэгт аймгийн Гамшигаас хамгаалах алба, Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг хамруулж, бэлтгэл, бэлэн байдлыг шалган, хөдөлмөр, хамгаалал аюулгүй ажиллагааг хангуулах мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгсөн бөгөөд Гамшигаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, хүн хүч техник хэрэгслийн бэлэн байдал ХАНГАЛТТАЙ үнэлэгдсэн. Мөн гамшигаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, харилцан ажиллагааг сайжруулах, зөрчил дутагдлыг арилгуулах, гамшигаас хамгаалах хууль тогтоомжийн талаар мэдлэг, мэдээлэл олгох сургалтад оролцсон.



Улсын бүртгэлийн хэлтэс нь аймгийн Цагдаагийн хэлтсийн хуучин байр болох 1971 онд ашиглалтанд орсон 100,5 м/кв талбайтай, өргөтгөл нь 2008 онд ашиглалтанд орсон нийт 506,94 м/кв талбайтай байранд урсгал засвар хийж, байрны нээлтээ 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулж, албан хаагчдын ажиллах тав, тухтай орчин нөхцлийг нэмэгдүүлсэн. Хэлтсийн байранд албан хаагчдын санаачлагаар "Галын сараа"-г хийлгэж, байршуулав. Байгууллагын хэмжээнд 5 ширхэг гал унтраагуур байна.



Барилгын газардуулгын хэмжилтийг "ЦДУС" ТӨКХ-ийн Зүүн өмнөд бүсийн Говьсүмбэр салбараар хийлгэж "Хэвийн" дүгнэлт авсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулагдаж буй Говьсүмбэр аймгийн 2024 оны хавар, намрын улиралд бүх нийтээр мод тарих арга хэмжээнд тус хэлтсийн давхардсан тоогоор 23 албан хаагч Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн талбайд болон "Говьсүмбэр-30" цэцэрлэгт хүрээлэнд хайлаас-90 улиас-90 нийт-180 ширхэг модыг 450.000 төгрөгөөр худалдан авч суулган, усалгааг бүрэн хийж тарьж ургуулсан. Ургалт 100 хувь байна.



Байгууллагын мод арчилгааны хариуцсан газарт хуваарийн дагуу цэнэг усалгааг хийж, модыг тогоолох, ойр орчимын хогийг цэвэрлэх ажлыг зохион байгуулсан.

БИЧИГ ХЭРГИЙН ЭРЛЭГЧ, НЯРАВ

ТАЙЛАН БИЧСЭН:

Х.МЯГМАРЖАРГАЛ

ДАРГА

З.БАЯНДУГАР

